



# APP

Азия Пасифик Пропертиз ХК

2015 оны 4-р сарын 30-ний өдөр

№ 62

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн даргыг сонгох тухай:

Компанийн тухай хуулийн 78.1, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 7.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн эцнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2015 оны анхдугаар хуралд оролцсон 8 гишүүний 88,8 хувийн саналаар Шаарийбуу овогтой Ганбат-ыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар сонгосугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө Төлөлөн Удирдах Зөвлөлийг удирдан зохион байгуулж ажиллахыг Ш.Ганбат-д үүрэг болгосугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд:

Д.Галбадрах

Ч.Энхбаяр

Л.Отгончимэг

М.Сосорбарам

Ч.Цогзолмаа

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүд:

Ш.Ганбат

Д.Намсрайжав

Н.Батжин



Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: [www.asiapacificproperties.mn](http://www.asiapacificproperties.mn) И-мэйл: [info@asiapacificproperties.mn](mailto:info@asiapacificproperties.mn)

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16

Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



# APR

Азия Пасифик Пропертиз ХК

2015 оны <sup>04</sup>...-р сарын <sup>30</sup>...-ний өдөр

№ 63

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцааг эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх тухай:

Компанийн тухай хуулийн 53.3 дах заалт болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 2.2.3-д заасныг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2015 оны 4-р сарын 27-ны өдөр болсон компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр компанийн хяналтын багцын хувьцааг эзэмшигч болох Азия Пасифик Инвестмент Партнерс Лимитед компанийн гаргасан саналыг үүгээр дэмжиж, 2015 оны 4-р сарын 27-ны өдрийн байдлаарх үнэт цаасны арилжааны хаалтын ханшаар буюу 2,460 /хоёр мянга дөрвөн зуун жаран/ төгрөгөөр нэгж хувьцааг хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдээс худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээллэж ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:  Ш.ГАНБАТ



Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: [www.asiapacificproperties.mn](http://www.asiapacificproperties.mn) И-мэйл: [info@asiapacificproperties.mn](mailto:info@asiapacificproperties.mn)

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16

Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот



# APP

Азия Пасифик Пропертиз ХК

2015 оны 4-р сарын 30-ний өдөр

№ 64

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах тухай:

Компанийн тухай хуулийн 81.2, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10.1 дэх заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлд Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
  - Аудитын хороог хараат бус гишүүн Ш.Ганбат, хараат бус гишүүн Д.Намсрайжав, ердийн гишүүн Б.Бямбажав нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар нь Ш.Ганбатыг
  - Цалин урамшууллын хороог хараат бус гишүүн Д.Намсрайжав, хараат бус гишүүн Н.Батжин, ердийн гишүүн Л.Отгончимэг нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар нь Д.Намсрайжавыг
  - Нэр дэвшүүлэх хороог хараат бус гишүүн Н.Батжин, хараат бус гишүүн Ш.Ганбат, ердийн гишүүн Д.Галбадрах нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар нь Н.Батжинг тус тус томилсугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Ш.ГАНБАТ

Утас: 94991014, 77300880 Факс: 976-77300880

Вэбсайт: [www.asiapacificproperties.mn](http://www.asiapacificproperties.mn) И-мэйл: [info@asiapacificproperties.mn](mailto:info@asiapacificproperties.mn)

Хаяг: Мөнгөл Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16  
Реженси Резиденс, 2-р давхар, 202 тоот